

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/18/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545

цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.4. Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт -1	Санхүүгийн байдлын тайлан	14
Хүснэгт -2	Авлагын үлдэгдэл	15
Хүснэгт -3	Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл	16



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.БАТЧУЛУУН ТАНАА

2022.03.20 № 2/21
танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,083,626,081.06	14,052,911,828.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,065,314,749.71	6,485,991,960.56
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,065,314,749.71	6,485,991,960.56
3121	Төгрөг	6,065,314,749.71	6,485,991,960.56
31211	Төрийн сангийн харилцах	145,099,963.41	83,885,391.90
31213	Арилжааны банк дахь харилцах	5,920,214,786.30	6,402,106,568.66
33	АВЛАГА	6,013,878,045.35	7,563,148,988.23
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	519,899,589.74	904,112,058.31
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,418,910,501.91	6,609,950,696.11
335	Бусад авлага	75,067,953.70	49,086,233.81
3351	Байгууллагаас авах авлага	75,067,953.70	49,086,233.81
35	БАРАА МАТЕРИАЛ	4,433,286.00	3,770,880.00
354	Хангамжийн материал	4,433,286.00	3,770,880.00
35420	Аж ахуйн материал	3,440,550.00	3,314,150.00
35470	Бусад хангамжийн материал	992,736.00	456,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,297,343,296.68	1,284,211,778.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,297,343,296.68	1,284,211,778.71
392	Биет хөрөнгө	1,279,961,296.68	1,266,829,778.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,311,956,731.58	1,311,956,731.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,799,257.99)	(124,618,221.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,300,000.00	15,390,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,915,641.00	65,931,046.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,745,977.11)	(30,520,460.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,285,012.00	63,285,012.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,650,852.80)	(34,594,329.12)
393	Биет бус хөрөнгө	17,382,000.00	17,382,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,382,000.00	17,382,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,380,969,377.74	15,337,123,607.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	209,730,904.08	203,132,772.79
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	209,730,904.08	203,132,772.79
413	Өглөг	12,363,116.68	22,936,655.37
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,363,116.68	22,936,655.37

414	Урьдчилж орсон орлого	197,367,787.40	180,196,117.42
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	197,367,787.40	180,196,117.42
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,171,238,473.66	15,133,990,834.71
51	Засгийн газрын хувь оролцоо	13,171,238,473.66	15,133,990,834.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	475,088,887.06	475,088,887.06
512	Хуримтлагдсан үр дүн	12,685,030,490.35	14,647,782,851.40
51210	Өмнөх үеийн үр дүн	4,213,520,164.31	12,719,101,490.36
51220	Тайлант үеийн үр дүн	8,471,510,326.04	1,928,681,361.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,119,096.25	11,119,096.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,380,969,377.74	15,337,123,607.50

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	72,507,248,200.00	69,455,366,465.44
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,570,180,591.35	36,073,975,008.80
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	32,570,180,591.35	36,073,975,008.80
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,192,973,675.10	25,975,645,797.41
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,271,466,626.40	2,390,592,704.56
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,470,681,378.41	1,583,504,175.02
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	417,924,625.43	450,713,718.91
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,217,134,286.01	5,673,518,612.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,238,058.78	63,137,525.64
120	Нийтлэг татварын бус орлого	88,238,058.78	63,137,525.64
120002	Хүүгийн орлого	75,648,899.28	10,016,331.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,589,159.50	51,337,644.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,021,659.50	25,600,643.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,567,500.00	297,001.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	25,440,000.00
120009	Бусад орлого		1,783,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,848,829,549.87	33,318,253,931.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,857,090.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,857,090.00	285,000.00
1330	Төсвийн захирагчдаас	38,223,995,659.87	32,515,275,631.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,223,995,659.87	32,515,275,631.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	780,776,800.00	802,693,300.00

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	780,776,800.00	802,693,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	64,035,737,817.72	67,527,113,094.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,035,737,817.72	67,527,113,094.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	799,535,517.72	761,675,326.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,605,348.33	514,220,849.50
210101	Үндсэн цалин	381,494,441.77	402,031,613.30
210102	Нэмэгдэл	91,445,181.56	83,307,237.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,932,000.00	22,041,999.20
210104	Урамшуулал	22,733,725.00	6,840,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,949,776.00	70,173,209.79
210201	Тэтгэврийн даатгал	43,477,380.06	48,552,843.86
210202	Тэтгэмжийн даатгал	5,371,346.48	5,403,337.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,293,180.19	4,322,669.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,071,671.30	1,080,667.43
210205	Эрүүл мэндийн даатгал	10,736,197.97	10,813,691.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,402,054.00	65,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,608,154.00	4,500,000.00
210302	Түлш, халаалт	60,541,600.00	56,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,252,300.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,003,029.00	25,560,700.00
210401	Бичиг хэрэг	7,602,000.00	8,163,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,329,500.00	11,383,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,225,893.00	2,427,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,347,900.00	959,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,497,736.00	2,625,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,475,750.00	4,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,868,450.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,607,300.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,269,500.00	2,269,000.00
210702	Дотоод албан томилолт	2,269,500.00	2,269,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,603,372.00	35,386,828.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,744,416.00	24,648,982.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,386,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,200.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	7,500.00
210807	Газрын төлбөр	50,440.00	37,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,049,540.00	6,269,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,101,776.00	1,923,386.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,226,688.39	44,864,738.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,856,200.00	2,285,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,370,488.39	42,579,738.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,236,202,300.00	66,765,437,768.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,094,505,530.00	60,330,032,245.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	57,059,142,569.00	60,264,475,738.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,599,561.00	9,104,010.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,763,400.00	56,452,497.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,141,696,770.00	6,435,405,523.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,141,696,770.00	6,435,405,523.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,471,510,382.28	1,928,253,371.04
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	427,990.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		427,990.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	427,990.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,471,510,382.28	1,928,681,361.04

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	4,202,727,255.20	4,688,935,238.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	10,792,909.11	10,792,909.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	4,213,520,164.31	4,699,728,147.62
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	8,471,510,326.04	8,471,510,326.04
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	12,685,030,490.35	13,171,238,473.66
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	12,685,030,490.35	13,171,238,473.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	34,071,000.01	34,071,000.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	12,719,101,490.36	13,205,309,473.67
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,928,681,361.04	1,928,681,361.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	14,647,782,851.40	15,133,990,834.71

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	67,069,155,201.08	67,955,087,879.64

11	ТАТВАРЫН ОРЛОГО	27,958,035,275.54	34,436,350,531.85
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	27,958,035,275.54	34,436,350,531.85
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,593,202,009.52	25,227,352,936.38
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,779,355,019.70	1,990,663,478.70
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,060,597,855.43	1,233,885,626.66
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	332,062,154.19	375,614,769.73
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,192,818,236.70	5,608,833,720.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	135,960,685.54	120,949,647.79
120	Нийтлэг татварын бус орлого	135,960,685.54	120,949,647.79
120002	Хүүгийн орлого	75,648,899.28	10,016,331.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,311,786.26	110,933,316.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,744,286.26	110,636,315.65
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,567,500.00	297,001.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,975,159,240.00	33,397,787,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	84,829,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		84,829,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,857,090.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,857,090.00	285,000.00
1330	Төсвийн захирагчдаас	38,185,525,350.00	32,509,980,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,185,525,350.00	32,509,980,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	780,776,800.00	802,693,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	780,776,800.00	802,693,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	64,127,188,726.26	67,534,410,668.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,127,188,726.26	67,534,410,668.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	733,125,866.33	710,774,891.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,353,373.33	514,220,849.50
210101	Үндсэн цалин	383,254,943.92	404,045,201.90
210102	Нэмэгдэл	90,816,931.41	81,293,648.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,158,000.00	22,041,999.20
210104	Урамшуулал	22,123,498.00	6,840,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,506,000.00	63,859,600.00
210201	Тэтгэврийн даатгал	48,535,516.40	44,338,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,996,246.20	4,880,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,792,646.60	3,904,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,196,349.00	976,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,985,241.80	9,760,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,402,054.00	65,200,000.00

210301	Гэрэл, цахилгаан	3,608,154.00	4,500,000.00
210302	Түлш, халаалт	60,541,600.00	56,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,252,300.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,819,293.00	25,434,300.00
210401	Бичиг хэрэг	7,363,800.00	8,163,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,329,500.00	11,383,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,225,893.00	2,427,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,347,900.00	959,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,552,200.00	2,499,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,475,750.00	4,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,868,450.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,607,300.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,269,500.00	2,269,000.00
210702	Дотоод албан томилолт	2,269,500.00	2,269,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,443,696.00	33,506,142.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,744,416.00	24,648,982.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,386,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,200.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	7,500.00
210807	Газрын төлбөр	50,440.00	37,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,049,540.00	6,269,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,942,100.00	42,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,856,200.00	2,285,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,856,200.00	2,285,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,394,062,859.93	66,823,635,777.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,252,466,058.56	60,388,558,274.15
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	57,191,666,466.08	60,299,432,488.79
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,599,561.00	9,104,010.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,436,631.48	23,569,278.36
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,763,400.00	56,452,497.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,141,596,801.37	6,435,077,503.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,141,596,801.37	6,435,077,503.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,941,966,474.82	420,677,210.85
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,936,966,474.82	420,677,210.85
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,128,448,274.89	6,065,314,749.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,065,314,749.71	6,485,991,960.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,564,021,500.00	61,073,826,187.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,564,021,500.00	61,073,826,187.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,132,500.00	710,447,191.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,921,800.00	514,220,849.50
210101	Үндсэн цалин	408,252,900.00	404,045,201.90
210102	Нэмэгдэл	98,710,500.00	81,293,648.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,118,400.00	22,041,999.20
210104	Урамшуулал	6,840,000.00	6,840,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,189,400.00	63,859,600.00
210201	Тэтгэврийн даатгал	48,592,600.00	44,338,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,399,200.00	4,880,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,319,400.00	3,904,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,079,800.00	976,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,798,400.00	9,760,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,200,000.00	65,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,500,000.00
210302	Түлш, халаалт	56,500,000.00	56,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,435,000.00	25,434,300.00
210401	Бичиг хэрэг	8,163,800.00	8,163,800.00
210402	Тээвэр, шатахуун	11,383,900.00	11,383,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,427,300.00	2,427,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	959,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,499,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,278,800.00	2,269,000.00
210702	Дотоод албан томилолт	2,278,800.00	2,269,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,107,500.00	33,463,442.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,665,100.00	24,648,982.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	7,500.00
210807	Газрын төлбөр	100,000.00	37,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,592,400.00	6,269,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,813,889,000.00	60,363,378,995.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,813,889,000.00	60,363,378,995.79
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	60,749,935,800.00	60,299,432,488.79
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,000.00	7,494,010.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,453,200.00	56,452,497.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,564,021,500.00	61,494,503,398.14
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,032,082,100.00	84,829,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	10,032,082,100.00	84,829,400.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	51,531,939,400.00	28,837,285,278.54
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	51,531,939,400.00	28,837,285,278.54
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	29,137,200.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	28,840,005.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	297,194.61
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	32,543,251,519.50
122001	Тохируулгын орлого зарлагын зөрүү	-	32,543,251,519.50
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,065,314,749.71
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,485,991,960.56
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46.00	45.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
620004	Гэрээт ажилтан	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,857,090.00	285,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,857,090.00	285,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,704,000.00	285,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,704,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,704,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	285,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		285,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,090.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,090.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	153,090.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,857,090.00	285,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,857,090.00	285,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,857,090.00	285,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд насжилт өндөртэй авлага бууруулах, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 3 дугаар сарын 23-наас 2022 оны 03 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 114 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн даатгалын хэлтэс нь Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй, аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн тушаал заавар журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилласан байна. Даатгуулагч болон төр аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шитгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх

даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болох өөрт нь болон даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлэн даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлж Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн тушаал заавар журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилласан байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- ✓ *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- ✓ *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- ✓ *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

НДЕГ-аас нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх 2018 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна. Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн эрхлэх асуудлын 2021 оны үйл ажиллагаанд НДЕГ-аас дотоод хяналт 2021 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 64035.7 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 320.2 сая

төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 256.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1956.2 сая төгрөгөөр буюу 35 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна.

Хүснэгт-1. Санхүүгийн байдлын тайлан

сая.төг

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	6,065.3	6,485.9	(420.6)	6.9%
Авлага	6,013.9	7,563.2	(1,549.3)	25/%
Бараа материал	4.4	3.8	0.6	14%
Үндсэн хөрөнгө	1,297.3	1,284.2	13.1	3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,380.9	15,337.1	(1,956.2)	15%
Богино хугацаат өр төлбөр	12.4	22.9	(10.5)	54%
Урт хугацаат өр төлбөр	197.4	180.2	17.2	9%
Цэвэр хөрөнгө, өмч	13,171.1	15,134.0	(1,962.9)	15%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,380.9	15,337.1	(1,956.2)	15%

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6065.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6485.9 сая төгрөг болж 420.6 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 6485.9 сая төгрөгийн 83.9 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 6402.1 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 6013.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7563.1 сая төгрөг болж 1549.1 сая төгрөг буюу 25 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая.

Төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	519.9	904.1	384.2
Байгууллагаас авах авлага	75.1	49.1	26.0
	5,418.9	6,609.9	1,191.0
АВЛАГЫН НИЙТ ДҮН	6,013.9	7,563.1	1,549.2

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд байгууллагаас авах авлага 49.1 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 904.1 сая, татаас санхүүжилтийн авлага 6609.9 сая нийт 7563.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас ЗГ-ын 211-р тогтоолоор хэрэгжсэн хөнгөлөлт чөлөөлөлтийн санхүүжилтийн авлага ихэнх хувийг эзэлж байна.

Аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага болох 904.1 сая төгрөгийн авлагаас НДҮЗ-ийн 2018 оны 06 сарын 11-ний өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ын дагуу үнэлэхэд орлогын 3.0 хувьтай байгаа тул хэвийн авлага гэж үзэж байгаач он дамжсан 5-аас дээш жил болсон насжилт өндөртэй 25.6 сая төгрөгийн авлага шийдвэрлээгүй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 3.8 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал худалдан авч зарцуулсантай холбоотой буурсан байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 26.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 1.7 сая төгрөг, нийт 27.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 28.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1297.3 сая төгрөг байсан бол оны эцэст 1284.2 сая төгрөг болж 13.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд нь хөрөнгө худалдаж аваагүй, НДЕГ-аас үнэ төлбөргүйгээр 29.4 сая төгрөгийн хөрөнгө орлого авч ТӨБЗГ-ын 2021 оны 12-р сарын 31-ны 5/2385 тоот тогтоолоор 80.3 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 29.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдаж аваагүй, үнэ төлбөргүй 427.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, НДЕГ-ын даргын 2021 оны 12-р сарын А/179 тоот тушаалаар 29.0 сая төгрөгийн акталсан хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоосноор орлого авч 80.3 сая төгрөгийн хөрөнгө акталж хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 209.7 сая, оны эцсийн үлдэгдэл 203.1 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 22.9 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой байна. Урьдчилж орсон орлого эрсдэлийн сангийн төсвийн өр 180.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөрийн 22.9 сая төгрөг нь шимтгэлийн илүү төлөлтийг буцаан байгууллагад өгөх барагдах боломжтой өр төлбөр байна.

Урьдчилж орсон орлогын өглөг нь ажил олгогчийн шимтгэлийн өглөг, үүний 45.2 сая нь төсөвт байгууллага, 23.6 сая нь ААНБ-н өглөг, 111.4 сая төгрөг нь он дамжиж гэрээ хийсэн сумдын өглөг байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 13171.2 сая төгрөг байсан оны эцэст 15133.9 сая төгрөг болж тайлант онд 1962.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1928.7 сая төгрөгийн ашигтай, өмнөх үеийн үр дүн рүү 34.0 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 61564.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 61564.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн төсвийг НДҮЗ-ийн 2021 оны 07-р сарын 21-ны өдрийн 11 дугаар тогтоолоор сангийн төсвийн орлогыг 34237.9 сая, улсын төсвөөс 26523.4 сая, үйл ажиллагааны төсвийг улсын төсвөөс 802.7 сая төгрөг нийт 61564.0 сая төгрөгөөр тус тус баталсан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн орлогыг 34237.9 сая, улсын төсвөөс 26523.4 сая, үйл ажиллагааны төсвийг улсын төсвөөс 802.7 сая төгрөг нийт 61564.0 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3. Төсвийн орлогын төлөвлөгөө *сая. төг*

Хүснэгт-3	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих	9,229.4	84.8
Үйл ажиллагааны төсөв	802.7	802.7
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	51,531.9	28,069.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	-	28.8
Туслах үйл ажиллагааны орлогоос	-	0.3
Тохируулгын орлого зарлагын зөрүүгээс		32,543.2
ЭХҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	61,564.0	61,529.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр оны эхний үлдэгдлээс 6065.3 сая төгрөг байсан. НДС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 7-р зүйлийн 7,7-д заасны дагуу тохируулгын орлого зарлагын зөрүүгээс 32543.2 сая, улсын төсвөөс 887.5 сая, нийгмийн даатгалын сангаас 28069.0 сая, үйл ажиллагааны орлогоос 29.1 сая, нийт 61529.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 61073.9 сая төгрөгийг зарцуулж 34.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж 6485.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь цалин хөлс 514.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 63.8 сая, тогтмол зардалд 65.2 сая, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжид 60363.4 сая, бусад бараа үйлчилгээний зардалд 132.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны орлого болох хүү, торгууль, алдангийн орлогоос 2021 онд 29.1 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар НДЕГ-аас сургалтын зардалд 285.0 мянган төгрөгийн санхүүжилт өгснөөс сургалтын гарын авлагын зардалд бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлэх ЗГ-ын 211 тоот тогтоолын дагуу аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлсэн шимтгэлийн хөнгөлөлт чөлөөлөлтийн 6609.9 сая төгрөгийн НДЕГ-аас авах авлага үүссэн асуудал нь үлэмж нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс 129 хугацаандаа оруулсан 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татах насжилт өндөртэй авлага, шимтгэлийн хөнгөлөлт чөлөөлтийн авлагын хэрэгжилтийн талаар авч үзэх шаардлагатай.

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлэх 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 79.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдсэнгүй.

4.2 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлсэн, тооцоо нийлж өр авлагаа баталгаажуулаагүй 1.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах,

Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Төлбөрийн акт тогтоох*

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: *Насжилт өндөртэй шимтгэлийн авлага шийдвэрлээгүй, авлагын үр дүн буурсан, тооцоо нийлж баталгаажуулаагүй 25.6 сая төгрөг байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Он дамжсан насжилт өндөртэй авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, авлагыг барагдуулах

4.4.2 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: *Ажилтан албан хаагчдын албан хэрэгцээнд зарцуулсан авто машинд олгосон шатахууны жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй, зарим явсан албан хаагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, замын хуудас дутуу и-баримтгүй гүйлгээ хийсэн, бараа материалын тайлан гаргалт хангалтгүй 7,9 сая төгрөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 тоот тогтоол "суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" гэсэн заалттай нийцээгүй.*

Өгсөн зөвлөмж: *Шатахууны тооцоо бодож хэвших, норм нормативыг баримтлах, замын хуудсаар баталгаажуулж баримтжуулах*

4.4.3 Төсвийн хэмнэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: *Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны зардлыг хянахад Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй 45.6 сая төгрөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2021/02/17-ны 43 тоот "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3, 1.6, 1.8, 1.9 дэх заалтуудтай нийцээгүй.*

Өгсөн зөвлөмж: *Дотоод хяналт хэрэгжүүлэн төсвийг хэмнэлттэй зарцуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 03-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	НДХ	3	55.0	0		1	1.5	0		2	53.5
2	НДС	1	25.6	0						1	25.6
	НИЙТ	4	80.6			1	1.5			3	79.1

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР